

МӨНГӨН ШАГНАЛ ХУВААРИЛАХ ЖУРАМ

1. Энэхүү журмын зорилго нь Монголын таеквондогийн холбоо /Цаашид Холбоо гэнэ/ болон түүний дасгалжуулагч нарын хооронд үүссэн мөнгөн шагнал хуваарилахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
2. Мөнгөн шагнал авах болзол хангасан тамирчин болон багт нэгээс дээш дасгалжуулагч ажилласан боловч тэдгээрийн хооронд байгуулсан мөнгөн шагнал хуваарилах гэрээ байхгүй тохиолдолд энэхүү журмыг дагаж мөрдөнө.
3. Дасгалжуулагчид олгох аливаа мөнгөн шагналыг холбооны Сургалт, дасгалжуулалтын зөвлөлийн дарга /цаашид Зөвлөлийн дарга гэнэ/-ын нэр дээр авна.
4. Зөвлөлийн дарга тус мөнгөн шагналыг холбоонд шилжүүлнэ.
5. Дасгалжуулагчид ногдох мөнгөн шагналын 10 хувийг холбоо авах эрхтэй. Холбоо тус мөнгийг холбооны зорилгын дагуу үйл ажиллагаанд зарцуулж тухай бүр тайлагнах үүрэгтэй.
6. Улсын аварга шалгаруулах тэмцээн, Хүүхдийн наадам, Бүх ард түмний спартакиад тэмцээний хувьд мөнгөн шагналын 20 хувийг дасгалжуулагч, 10 хувийг холбоонд олгоно.
7. Тивийн наадам, Гран-При тэмцээн, Оюутны юниверсиад тэмцээнүүдийн хувьд дасгалжуулагчид олгох Засгийн Газрын мөнгөн шагналын 10 хувийг анхны багш дасгалжуулагчдад, 35 хувийг тамирчны харьяалах байгууллагын дасгалжуулагчдад, 45 хувийг шигшээ багийн дасгалжуулагчдад тус тус олгоно.
8. Олимпын наадам, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний хувьд Засгийн Газрын мөнгөн шагналын 5 хувийг анхны багшид, 15 хувийг харьяалах байгууллагын дасгалжуулагчдад, 70 хувийг шигшээ багийн дасгалжуулагчдад тус тус олгоно.
9. Мөнгөн шагнал авах болзол хангасан тамирчин нь шигшээ баг дээр бэлтгэл хийдэггүй, шигшээ багийн тамирчин биш тохиолдолд ДТХ-оос олгодог дасгалжуулагчийн мөнгөн шагналыг түүний харьяалах байгууллагын дасгалжуулагчид олгоно.

10. Харьяалах байгууллагын дасгалжуулагч гэдэгт тамирчинд сар бүр тогтмол цалин олгодог, бэлтгэл сургуулилт хийлгэдэг, бэлтгэл цугларалт болон тэмцээний зардал гаргадаг клуб, спорт хороо, нийгэмлэг, академи, дэвжээний дасгалжуулагчдыг ойлгоно.
11. Анхны багш гэдэгт тухайн тамирчинг өндөр зэрэглэлийн тамирчин болоход бодит хувь нэмэр оруулсан, нэгээс дээш жил тууштай бэлтгэл сургуулилт хийлгэсэн, тухайн тамирчинтай байнгын харилцаатай байж зөвөлгөө өгч амжилт гаргахад нь тусалдаг, дэмждэг багш дасгалжуулагчийг ойлгоно. Анхны багш нь нэгээс дээш дасгалжуулагч байж болно.
12. Анхны багш нас барсан тохиолдолд түүнд оногдох мөнгөн шагналыг түүний ар гэрт буюу эхнэр, хүүхдэд олгоно.

---oOo---